



## НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

### Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/415 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм”-ийн 4.1 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/495 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/46 дугаар тушаалаар баталсан “Газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар, орон тооны хязгаарыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Баталсан дүрэм, бүтцийг үйл ажиллагаандаа мөрдөж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв (Ч.Өнөрсайхан)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтэс (У.Бат-Очир)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2016 оны А/26 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  П.ЭРХЭМБУЛГАН



1550010195

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын  
даргын 2024 оны 15 сарын 24 өдрийн  
1177 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв /цаашид төв гэх/ нь харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, нийслэлийн эрүүл мэндийн газар, СХД-ийн ЗДТГ-ын бодлого, чиглэл, шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих, дүүргийн хүн амд лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эмнэлэг байна.

1.2 Эрүүл мэндийн төв нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаал, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3 Эрүүл мэндийн төв нь Алсын хараа-2050, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, Нийслэлийн эрүүл мэндийн газрын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан "Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө"-тэй байна.

1.4 Эрүүл мэндийн төв нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, бэлэгдэл, санхүүгийн харилцах данстай байна.

1.5 Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагааны явц, үр дүнг Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын өмнө хариуцаж тайлагнана

1.6 Эрүүл мэндийн төв нь албан ёсны цахим хуудастай байж, тогтмол шинэчлэн баяжуулж ажиллана.

### ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

Эрүүл мэндийн төв нь дараах зарчмыг баримтална.

2.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож, улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан, нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах;

2.2..Эрүүл мэндийн бодлого, арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, гэр бүл, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх.

2.3.Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн төр хариуцах зарим төрлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх.

2.4.Хүмүүнлэг, энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэг, ололт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;

2.5.Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш,

хүртээмжтэй үзүүлэх;

2.6. Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр эрүүл мэндийн байгууллагад адил тэгш хандах;

2.7. Мэргэшсэн, тогтвортой байх (Хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой байдлыг хангаж, эмч эмнэлгийн мэргэжилтэн ажилтныг албан тушаалын шаардлагад нийцүүлэн томилно).

2.8. Тусламж, үйлчилгээнд олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт удирдамжийг ашиглаж үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг бүрэн хангана.

## **ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙ**

### **3.1. Алсын хараа**

Олон улсын стандартыг хэрэгжүүлэгч эмнэлэг болно.

### **3.2. Эрхэм зорилго**

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг эрхэмлэн, нотолгоонд суурилсан, анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, чанартай аюулгүй тусламж үйлчилгээтэй, манлайлагч эмнэлэг болно .

### **3.3. Үнэт зүйл:**

С- Сэтгэл ханамж

Х- Хариуцлагатай байдал

Д- Дэвшилтэт технологи

Э- Ээлтэй орчин

М-Мэргэшсэн баг

Т- Түүхэн замнал

## **ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ЭРХ, ҮҮРЭГ**

4.1 Төв нь эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1 Засгийн газрын болон нийслэл, дүүргийн хэмжээнд хэрэгжүүлж буй эрүүл мэндийн хөтөлбөрийг өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжүүлэх, үр дүнг тооцох

4.1.2 Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах ажлыг зохион байгуулж, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлийг судлан тогтоож, арилгах арга хэмжээ авч ажиллах

4.1.3 Эх барих, эмэгтэйчүүд, нярайн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах

4.1.4 Амбулаториор үйлчлүүлэгчдэд үзлэг, оношилгоо, эмчилгээг батлагдсан стандарт, эмнэл зүйн удирдамжийн дагуу хийж, оношийг тодруулан эмчилж, шаардлагатай бол төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэг рүү хэвтэх бичгээр илгээх

4.1.5 Сүүлийн үеийн анагаах ухааны дэвшилтэт технологи, ололт амжилтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, дотоод гадаадын ижил мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох;

4.1.6 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тулгамдсан асуудлаар нотолгоонд суурилсан үндэслэл бүхий санал боловсруулж, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэх;

4.1.7 Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар оролцох;

4.1.8 Гамшиг, онцгой байдлын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг жил бүр тодотгож, эмч, мэргэжилтнүүдийг тогтмол дадлага сургуулилтанд хамруулж, мэргэшүүлсэн байна. Болзошгүй гамшиг осол, олон улсын хөл хориот өвчний үед яаралтай эмнэлгийн

тусламж үйлчилгээний бэлэн байдлыг дүүргийн хэмжээнд хангаж ажиллана.

4.1.9 Төв нь байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллана.

4.1.10 Төв нь үйл ажиллагаандаа мэдээллийн технологийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, цахим мэдээллийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

4.1.11 Төв нь гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

## **ТАВ. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

5.1. Эрүүл мэндийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга батална.

5.2. Эрүүл мэндийн төвийн даргыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга томилж, чөлөөлнө.

5.3. Эрүүл мэндийн төв нь урт хугацааны болон жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд төлөвлөгөөг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга батална.

5.4. Эрүүл мэндийн төв нь дээд шатны Төсвийн захирагчтай жил бүр үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж, биелэлтийг бүрэн хариуцна.

5.5. Эрүүл мэндийн төв нь байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өдөр тутмын асуудлаар даргын зөвлөл, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах удирдлагын зөвлөлийг байгуулан ажиллуулна.

5.6 Төв нь Стратеги төлөвлөлт, үйл ажиллагаа хариуцсан орлогч дарга, Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга, Сувилахуйн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч даргатай байна.

5.7 Төвийн орлогч дарга нар өөрийн хариуцсан чиг үүргийг даргын удирдлага дор гүйцэтгэж, тайлагнах, хариуцлага хүлээнэ.

5.8 Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг төвийн дарга тушаалаар батлана.

5.9 Төв нь дэргэдээ орон тооны бус зөвлөл болон салбар хороодыг төвийн даргын тушаалаар байгуулан ажиллуулж болно.

5.10 Төвийн зохион байгуулалтын нэгж нь алба, тасаг байна. Нэгжийн удирдлага нь тухайн төв, алба, тасгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллана.

5.11 Төв нь ажилтнуудын хөдөлмөрлөх эрх ашгийг хамгаалах, ажиллах нөхцөл болон нийгмийн хамгааллыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилго бүхий “Үйлдвэрчний эвлэл”-тэй байж болно.

5.12 Даргын зөвлөл нь Эрүүл мэндийн төвийн дарга, чиглэл хариуцсан орлогч дарга нар, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга, захиргаа хүний нөөцийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллана. Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүнд бүх нэгжийн эрхлэгч нар орж ажиллана. Даргын зөвлөл, удирдлагын зөвлөлийн ажиллах журмыг Эрүүл мэндийн төвийн дарга батална.

5.13 Эрүүл мэндийн төвийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.13.1 Удирдах ажилтнуудыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах

5.13.2 Батлагдсан бүтэц, орон тоо болон хуулиар тогтоосон эрх, хэмжээний хүрээнд ажилтныг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ноогдуулах;

5.13.3 Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, ажилтны цалин хөлс, урамшууллын хэмжээг Засгийн газраас тогтоосон цалингийн сүлжээний доод жишгээр болон түүнээс дээш тогтоох;

5.13.4 Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, журам баталж мөрдүүлэх;

5.13.5 Орлогч дарга болон албадын дарга, тасаг, амбулаторийн эрхлэгч, албан

- хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;
- 5.13.6 Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 5.13.7 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд орон нутгийн засаг захиргааны байгууллага, эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллах;
- 5.13.8 Сахилга дэг журам, эрүүл мэндийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтны ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах;
- 5.13.9 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны нийгмийн асуудлыг хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ авч ажиллах;
- 5.13.10 Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйг сайжруулах ажлыг зохион байгуулах;
- 5.13.11 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног, төхөөрөмж, хөрөнгө оруулалтын асуудлыг Нийслэлийн эрүүл мэндийн газар болон бусад холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх;
- 5.13.12 Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргаас өгсөн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;
- 5.14 Хууль, тогтоомжид заасан бусад чиг үүрэг.
- 5.14.1 Эрүүл мэндийн төвийн дарга, албан хаагчид Улсын их хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн тамгын газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргаар дамжуулан харилцана.
- 5.14.2 Эрүүл мэндийн төвийн дарга хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгавар, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг тогтоосон хугацаанд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнаж, ажиллана.

## **ЗУРГАА. САНХҮҮЖИЛТ**

Эрүүл мэндийн төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 6.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр хийгдэх санхүүжилт;
- 6.2. Үндсэн (Хууль тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого), үндсэн бус (хууль тогтоомжид нийцүүлэн олсон бусад орлого гэх мэт) үйл ажиллагааны орлого;
- 6.3. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж;
- 6.4. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 6.5. Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 6.6. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр;

## **ДОЛОО. ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА**

- 7.1. Эрүүл мэндийн төвийн даргын гадаад улсад туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 7.2. Эрүүл мэндийн төв нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, хэлтсийн дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг

биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

7.3. Эрүүл мэндийн төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

7.4 Эрүүл мэндийн төв нь гадаад хамтын ажиллагааг төрөл бүрээр өргөжүүлж, өндөр хөгжилтэй орны дэвшилтэт болон Монгол улсад нэвтрээгүй техник технологийг нэвтрүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад улсад сургах, мэргэжил дээшлүүлэх боломжийг эрэлхийлж ажиллана.

7.5 Олон улсын хурал, зөвлөгөөн бусад ёслолын арга хэмжээнд оролцох тохиолдолд урилгыг Захиргаа, хүний нөөцийн албаны дарга хүлээн авч танилцан, тухайн арга хэмжээнд хэрхэн оролцуулах саналыг Эрүүл мэндийн төвийн даргын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлнэ.

7.6 Эрүүл мэндийн төвийн урилгаар гадаад дотоодын төлөөлөгчдийг хүлээж авахдаа, айлчлалын албан ёсны арга хэмжээний удирдамж, төсвийн төслийг батлуулсан байна.

7.7 Гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах, илтгэл тавих, сургалтад хамрагдах ажилчдын нэрсийг Удирдлагын зөвлөлд Хүний нөөцийн албаны дарга, Гадаад харилцаа, сургалт хариуцсан менежер танилцуулах бөгөөд Эрүүл мэндийн төвийн дарга эцэслэн шийдвэрлэнэ.

7.8 Гадаад томилолт, сургалт, аливаа үйл ажиллагааны зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж, шийдвэрлэнэ.

## **НАЙМ. ОРЛОГЧ ДАРГА НАРЫН ЧИГ ҮҮРЭГ**

Эрүүл мэндийн төвийг нийт гурван орлогч дарга гурван чиглэлээр хариуцаж, алба, тасгуудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

### **8.1.Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан орлогч даргын чиг үүрэг**

8.1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, холбогдох албадын үйл ажиллагааг уялдуулан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны үр дүнг хариуцан ажиллах;

8.1.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр стандарт, дүрэм, журам, удирдамж, заавар, аргачлал боловсруулан хэрэгжүүлэх, хяналт тавих;

8.1.3. Тусламж, үйлчилгээтэй холбоотой үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж сайжруулах санал, шийдвэрийн төслийг Удирдлагын зөвлөлд танилцуулан шийдвэрлэж ажиллах;

8.1.4. Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг биелүүлэн ажиллана.

### **8.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан орлогч даргын чиг үүрэг**

8.2.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, өрхийн эрүүл мэндийн төвүүд болон холбогдох албадын үйл ажиллагааг уялдуулан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны үр дүнг хариуцан ажиллах;

8.2.2. Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах

8.2.3. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, байгууллагын бодлого, төлөвлөлттэй уялдуулан ажиллах

8.2.4. Хүн амд үзүүлэх сүрьеэгийн диспансерийн үйл ажиллагаанд удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих

8.2.5. Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг биелүүлэн ажиллана.

### **8.3. Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан орлогч даргын чиг үүрэг**

8.3.1. "Сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх стратеги", бодлогын баримт бичгийн

хэрэгжилтийг ханган эрүүл мэндийн тогтолцоо, сургалт эрдэм шинжилгээний бүхий л орчинд сувилагч, эмнэлгийн мэргэжилтний манлайллыг бэхжүүлэх;

8.3.2.Сувилахуйн тусламж үйлчилгээг эрүүл мэндийн төвийн үндсэн зорилготой уялдуулан төлөвлөх, нэгдсэн арга зүйгээр хангах, хэрэгжүүлэх;

8.3.3.Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний үзүүлэх тусламж үйлчилгээний стандарт, дүрэм, журам, удирдамж, заавар, аргачлалын хэрэгжилтийг хангах, хяналт тавих, дэмжин туслах, арга зүйн зөвлөгөө өгөх;

8.3.4.Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавих, чанарыг тасралтгүй сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжүүлж ажиллах;

8.3.5.Шинээр ажилд орсон сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг ажлын байранд сургах арга хэмжээг хэрэгжүүлэх; сувилагч тусгай мэргэжилтнийг төгсөлтийн дараах тасралгүй сургалтанд хамруулах, хөгжүүлэх, судлаач сувилагч, тусгай мэргэжилтнийг бэлтгэх

8.3.6.Эмнэлгийн мэргэжилтнүүдийг олон нийттэй харилцах ур чадвар эзэмшүүлэх, үйлчилгээний соёлыг бий болгох.

8.3.7 Сувилахуйн албаны харъяанд тасаг нэгжийн арга зүйч сувилагч, сувилагч, бага эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдана.

#### **8.4 Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан орлогч даргын чиг үүрэг**

8.4.1.Эрүүл мэндийн төвийн стратеги төлөвлөгөө болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хөгжлийн чиг хандлага, шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

8.4.2.Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эдийн засгийн төлөвлөлт, үр ашгийн тооцоог хийх ажлыг удирдлагаар хангах;

8.4.3.Статистик, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах;

8.4.4.Эмнэлгийн цахим мэдээллийн технологийг салбарын бодлого хөтөлбөртэй уялдуулан хөгжүүлэх, удирдан зохион байгуулах;

8.4.5.Монгол Улсын шинжлэх ухаан технологийн хөгжлийн бодлого, дэлхийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн эмнэлгийн эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх;

### **ЁС. ЭМНЭЛГИЙН АЛБАДЫН ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ**

#### **9.1. Захиргаа хүний нөөцийн алба**

9.1.1.Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратегитай уялдуулан эмнэлгийн хүний нөөцийн хэрэгцээ, нийгмийн баталгаа, хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

9.1.2.Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрийн төслийг холбогдох албатай хамтран боловсруулах, албан хаагчтай холбоотой шийдвэр гаргахад удирдлагад дэмжлэг үзүүлэх;

9.1.3.Ажилтны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж батлуулах, ажил үүргийн хуваарилалтад үнэлгээ хийх

9.1.4.Байгууллагын үйл ажиллагааны журам, үйлчилгээний стандарт, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдүүлж хэвшүүлэх, эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын үр дүн, мэргэшил, ур чадварын түвшин, сахилга, ёс зүйд тавигдах шаардлага, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих;

9.1.5.Эмч, эмнэлгийн ажилчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх;

9.1.6. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг төлөвлөх, хяналт-үнэлгээг нэгдсэн удирдлагаар хангах, үр дүнг тооцох;

9.1.7. Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт сурталчилгаа болон хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийг салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах;

9.1.8. Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг батлагдсан стандарт, журмын хүрээнд хөтөлж, төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх, байгууллагын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах

## **9.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ чанар аюулгүй байдлын алба**

9.2.1. Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

9.2.2. Тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах, үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, эрсдэл, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд хяналт тавих, дэмжин туслах, арга зүйн зөвлөгөө өгөх, зохицуулах;

9.2.3. Чанарын удирдлагын тогтолцооны чиглэлээр ажилладаг эрх бүхий байгууллагууд, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, зөвлөл, иргэдийн төлөөлөлттэй хамтран ажиллах;

## **9.3. Дотоод хяналтын ажилтан**

9.3.1. Дотоод хяналтын ажилтан нь байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, шаардлагатай тохиолдолд байгууллагын тодорхой чиг үүрэгт үнэлгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж гаргах;

9.3.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөндлөнгийн байгууллагаар хийлгэх үнэлгээг зохион байгуулах, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, тушаал, гэрээ хянах;

## **9.4. Санхүү, бүртгэлийн алба**

9.4.1. Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын хэмжээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, үйл ажиллагааны үр дүн болон үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах;

9.4.2. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг Монгол Улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн акт, шийдвэрийг хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр удирдлагыг хангах;

9.4.3. Салбарын санхүүжилтийн шинэчлэл, гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулан өөрийн байгууллагын зүгээс үзүүлэх тусламж үйлчилгээний хүрээ, тоо хэмжээг төлбөрийн аргад суурилан төлөвлөн хэрэгжүүлэх;

9.4.4. Эрүүл мэндийн төвийн үндсэн чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, нөөц, үйл ажиллагааг холбогдох хууль эрхзүйн хүрээнд төлөвлөх, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтэнд төлөвлөлт хийж, удирдлагыг мэдээллээр хангах;

9.4.5. Төсвийн тухай хуулийн дагуу жил бүрийн төсвийн төсөөллийг батлуулан хүргүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зохион байгуулах;

9.4.6. Гүйцэтгэлийн санхүүжилтийн судалгаанд үндэслэн хамгийн үр ашигтай тусламж, үйлчилгээрүү чиглэсэн төлөвлөлтийг боловсруулан зах зээлд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

9.4.7. Холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үүрэг, чиглэлийн

хэрэгжилтийг хангаж, биелэлт, үр дүнг тооцох, албаны эд хөрөнгө, тусгай хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бэлэн байдлыг хариуцах;

9.4.8. Эрүүл мэндийн төвийн эмчилгээ, үйлчилгээг хэвийн явуулахад шаардагдах аж, ахуй, эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн хангамж нөхцлийг бүрдүүлэх, нөөцлөх, хяналт тавих, удирдлага зохион байгуулалтаар хангах.

9.4.9. Нийтлэг үйлчилгээ, аж ахуйн ажилтнуудыг удирдлага, зохион байгуулалтаар ханган өдөр тутмын ажил үүрэгт хяналт тавих

9.4.10. Аж ахуйн болон эмчилгээ үйлчилгээнд шаардагдах материалын хангамж, нийлүүлэлт, байгууллагын эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ханган нийлүүлэлт, зарцуулалтад хяналт тавих, зохион байгуулалтаар хангах

9.4.11. Ус, цахилгаан, дулааны шугам сүлжээ, эвдрэл, гэмтэл, барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавих, хариуцах

## **9.5 Халдварын сэргийлэлт, хяналтын тасаг**

9.5.1 Төвийн тусламж үйлчилгээний онцлогт тохирсон халдварын сэргийлэлт, хяналтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, тулгамдсан асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга хэмжээний саналыг холбогдох албан тушаалтан, удирдлагуудад мэдээлэх, мэргэжил арга зүйгээр хангах;

## **9.6 Амбулатори**

9.6.1 Төрөлжсөн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүртээмжтэй, жигд хүргэх үйл ажиллагааг зохион байгуулах

## **9.7 Онош зүйн нэгдсэн тасаг:**

9.7.1 Лаборатори, дүрс оношилгоо, дуран оношилгооны тусламж үйлчилгээг холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу үзүүлж, эмнэлзүйн онош баталгаажуулах, эмчилгээний үр дүнг хянахад шаардлагатай нотолгоо, дүгнэлтийг үнэн зөв гаргах; Шинжилгээний болон тоног төхөөрөмжийн стандарт ажиллагааны болон аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулж мөрдөх;

## **9.8 Сувилахуйн алба:**

9.8.1 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, мэргэжлийн болон ёс зүйн зөрчил, харилцаа хандлагатай холбоотой эрсдэл гаргахаас урьдчилан сэргийлэх, сувилахуйн гардан үйлдлийн болон түгээмэл үйлдлийн стандартыг мөрдүүлэх, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, халдвар хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

## **9.9 Эм зүйн тасаг:**

9.9.1 Эмийн санд тавигдах нийтлэг шалгуурын дагуу үйл ажиллагааг зохион байгуулах, Эмийн эмчилгээг үр дүнтэй, тасралтгүй явуулах, эмийн аюулгүй байдлыг хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

## **9.10 Нийгмийн эрүүл мэндийн алба**

9.10.1 Нийгмийн эрүүл мэндийн талаар баримтлах хөгжлийн бодлого, чиглэл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлаар эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах

## **9.11 Даатгал, статистик мэдээллийн алба**

9.11.1 Төвийн тусламж үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, бусад хууль, тогтоомжтой уялдуулан үйл ажиллагааг зохион байгуулах, бүтцийн нэгжүүдийг арга зүйгээр хангаж, дэмжлэх үзүүлэх;

9.11.2 Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай холбоотой эдийн засгийн судалгаа, төсвийн төслийн судалгааг бодит мэдээллийг үндэслэн боловсруулах, төлөвлөх, байгууллагын хэтийн болон дунд, богино хугацааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай эдийн засгийн судалгааг боловруулах, удирдлагыг мэргэжил арга зүйгээр хангах

9.11.3 Байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээллийг холбогдох дүрэм журмыг баримтлан гаргах, мэдээлэх, тайлагнах

#### **9.12 Мэдээлэл технологи, инженер техникийн алба:**

9.12.1 Төвийн хэмжээнд цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, боловсруулах, баяжуулах, ашиглах журмыг батлуулан мөрдүүлэх, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх, санал боловсруулан шийдвэрлэх;

9.12.2 Эмнэлгий тоног төхөөрөмжийн ашиглалтын талаарх заавар, ном, товхимол, зөвлөмж боловсруулах, хэвлэн нийтлэх, батлуулах, холбогдох тушаал шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллахад шаардлагатай төсөв хөрөнгийн асуудлыг удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх;

#### **9.13 Хэвтүүлэн эмчлэх тасаг**

9.13.1 Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг батлагдсан стандарт, эмнэл зүйн удирдамжийн дагуу үзүүлж, оношийг тодруулан эмчилж, шаардлагатай тохиолдолд дээд шатлалын эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэгт шилжүүлэх

#### **9.14 Баянхошуу салбар**

9.14.1 Ахмад наснуудыг хүлээн авч, хэвтүүлэн эмчилж сувилах тусламж үйлчилгээг үзүүлэх

9.14.2 Төрөлжсөн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүртээмжтэй, жигд хүргэх үйл ажиллагааг зохион байгуулах

#### **9.15 Өдрийн эмчилгээний тасаг**

9.15.1 Батлагдсан удирдамж, стандартын дагуу эмийн болон сэргээн засах, уламжлалт эмчилгээг үйлчлүүлэгчид өдрөөр үзүүлэх

#### **9.16 Үйлчлүүлэгчийг дэмжих алба**

9.16.1 Үйлчлүүлэгчийг дэмжих алба нь үйлчлүүлэгчийг чиглүүлэх, үйлчлүүлэгчийн сэтгэлд нийцсэн тусламж үйлчилгээний шийдлийг тодорхойлох, үйлчлүүлэгч тэдний гэр бүлд эрүүл мэндийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх

#### **9.17 Аж ахуй, хангамж үйлчилгээний алба:**


9.17.1 Төвийн барилга байгууламж болон түүний дулаан, цахилгаан, усан хангамж, агааржуулалт, тавилга, эд аж ахуй, эзэмшлийн зам талбайн бүрэн бүтэн байдал, ашиглалтыг хариуцан ажиллах;

#### **Арав. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах**

10.1. Эрүүл мэндийн төвийн даргын саналыг үндэслэн Нийслэлийн Эрүүл мэндийн газрын тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын  
 2024 оны 02 дугаар сарын 08 -ны өдрийн  
 А.Т.Т. дугаар тушаалын 2 дугаар хэвсрэлт

9023070010  
 9077456 ☎ СБТ22558



Нийслэлийн Эрүүл мэндийн газрын  
даргын 2024 оны 25 сарын 02 өдрийн  
...1177... дугаар тушаалын гуравдугаар  
хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ОРОН ТООНЫ  
ДЭЭД ХЯЗГААР

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Орон тооны дээд хязгаар
1	Эрүүл мэндийн төвийн дарга	1
7	Эрүүл мэндийн төвийн орон тоо	446
	<b>Нийт</b>	<b>447</b>

Жич: Орон тооны хязгаарт үндсэн болон гэрээт ажилтан хамаарах ба эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж байгаа эмнэлгийн мэргэжилтний тоо хамаарахгүй бөгөөд санхүүжилтийн хүрээ хязгаарт багтаан ажиллана.